



МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖИЙН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН ТУШААЛ

2019 оны 08 сарын 13 өдөр

Дугаар A/58

Улаанбаатар хот

Арилжаанд оролцох эрхийг сэргээх тухай

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 83 дугаар зүйлийн 83.1, "Монголын хөрөнгийн бирж" төрийн өмчит хувьцаат компанийн Дүрмийн 8 дугаар зүйлийн 8.1, 8.10.11, Гишүүнчлэлийн журмын 5 дугаар зүйлийн 5.3.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ НЬ:

1. Гүйцэтгэх захирлын 2019 оны 8 дугаар сарын 13-ны өдрийн A/56 дугаар тушаалаар арилжаанд оролцох эрх нь хязгаарлагдсан "Инвэскор капитал ҮЦК" ХХК, "Нэйшнл секюритис ҮЦК" ХХК-уудын арилжаанд оролцох эрхийг 2019 оны 08 дугаар сарын 13-ны өдрөөс эхлэн сэргээсүгэй.
2. Цаашид хууль тогтоомж, журам заавар болон "Монголын хөрөнгийн бирж" төрийн өмчит хувьцаат компанитай байгуулсан "Гишүүнчлэлийн гэрээ"-гээр хүлээсэн үүргээ тогтмол биелүүлэн ажиллахыг "Инвэскор капитал ҮЦК" ХХК /Г.Уянгахишиг/-д, "Нэйшнл секюритис ҮЦК" ХХК /С.Хатанбаатар/-д тус тус анхааруулсугай.
3. Үнэт цаасны арилжааны програмд нэвтрэх эрх сэргээхийг Үйл ажиллагааны газрын Арилжааны алба /Д.Алдармаа/-нд, тушаалын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Хяналт, зохицуулалтын газрын Хяналт шинжилгээний алба /Д.Баттулга/-нд тус тус үүрэг болгосугай.

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ



Х.АЛТАЙ